



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/631

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 118 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ГААОНӨГ/202107062 дугаартай Бугат, Жаргалан, Шарга, Цогт сумдад баригдах 120 айлын орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлыг “ДНТ” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Гаадамба)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Гаадамба)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Ж.Мөнхцэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ